

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
6. Албан шаардлага.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БХОМ	Богд хааны ордон музей
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН
ЗАХИРАЛ Ц.ЭРДЭНЭБААТАР
ТАНАА

2022.02.25 № 07/411
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд хааны ордон музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	385,139,412.10	377,067,246.32
33	АВЛАГА	66,986,351.80	71,626,365.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	154,400.80	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	14,017,500.00	14,059,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	29,230,648.18
335	Бусад авлага	52,814,451.00	28,336,217.00
3351	Байгууллагаас авах авлага	52,814,451.00	28,200,530.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	135,687.00
34	УРЬДЧИЛГАА	83,430,000.00	69,180,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	83,430,000.00	69,080,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	100,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	234,723,060.30	236,260,881.14
351	Түүхий эд материал	195,300.00	130,700.00
35130	Эм боох материал	195,300.00	130,700.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,384,000.00	12,508,348.00
354	Хангамжийн материал	222,143,760.30	223,621,833.14
35410	Бичиг хэргийн материал	9,543,296.00	6,509,085.00
35420	Аж ахуйн материал	78,712,333.30	84,705,340.30
35440	Түлш, шатах тослох материал	141,000.00	57,898.74
35470	Бусад хангамжийн материал	133,747,131.00	132,349,509.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,708,283,687.90	17,639,050,589.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,708,283,687.90	17,639,050,589.56
392	Биет хөрөнгө	16,292,933,187.30	16,236,664,088.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,028,891,829.34	2,078,891,829.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(655,597,437.62)	(739,005,526.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,077,777.78	20,077,777.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,077,777.78)	(20,077,777.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	337,747,098.35	360,633,492.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(253,457,973.59)	(300,936,765.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	200,244,624.38	207,995,624.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(168,646,297.55)	(178,259,453.17)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,785,597,927.99	14,785,597,927.99
39217	Ном	18,153,416.00	21,746,961.00
393	Биет бус хөрөнгө	1,415,350,500.60	1,402,386,500.60
39301	Программ хангамж	20,740,000.00	20,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,314,000.10)	(20,278,000.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,401,924,500.70	1,401,924,500.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,093,423,100.00	18,016,117,835.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,575,564.00	4,961,068.45
41	ДОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,575,564.00	4,961,068.45
413	Өглөг	1,575,564.00	4,961,068.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,575,564.00	1,668,074.45
4136	Бусад өглөг	0.00	3,292,994.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	3,292,994.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,091,847,536.00	18,011,156,767.43
51	Засгийн газрын хувь оролцоо	18,091,847,536.00	18,011,156,767.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,686,944,613.60	4,686,944,613.60
51101	Өмч: - төрийн	4,686,944,613.60	4,686,944,613.60
512	Хуримтлагдсан үр дүн	(74,954,276.79)	(155,645,045.36)
51210	Өмнөх үеийн үр дүн	55,653,816.00	(74,954,276.79)
51220	Тайлант үеийн үр дүн	(130,608,092.79)	(80,690,768.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,479,857,199.19	13,479,857,199.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	18,093,423,100.00	18,016,117,835.88

	ДҮН VI=IV+V		
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан			
<i>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон</i>			<i>/төгрөгөөр/</i>
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	501,862,000.00	540,151,425.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		23,211,125.00
120	Нийтлэг татварын бус орлого		21,471,125.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		21,471,125.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,165,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10,305,625.00
122	Тусламжийн орлого		1,740,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		1,740,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	501,862,000.00	516,940,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	428,314,300.00	304,701,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	428,314,300.00	304,701,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,547,700.00	74,562,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		37,825,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,547,700.00	36,737,900.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	137,676,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	137,676,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	580,451,128.24	620,842,193.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	580,451,128.24	620,842,193.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,627,487.95	567,093,948.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,593,565.96	222,779,005.38
210101	Үндсэн цалин	118,901,299.96	165,720,287.32
210102	Нэмэгдэл	54,223,266.00	36,085,545.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,469,000.00	16,540,175.66
210104	Урамшуулал		4,432,997.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,666,686.01	30,065,444.59
210201	Тэтгэврийн даатгал	20,538,132.86	21,229,370.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,582,505.79	2,303,178.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,012,272.83	1,785,422.76
210204	Ажилгүйдлийн даатгал	503,142.96	426,851.85
210205	Эрүүл мэндийн даатгал	5,030,631.58	4,320,621.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,393,029.25	27,769,704.51
210301	Гэрэл, цахилгаан	17,441,138.00	12,470,117.82
210302	Түлш, халаалт	14,145,833.77	13,259,377.69
210303	Цэвэр, бохир ус	1,806,057.48	2,040,209.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,732,429.56	51,207,082.31
210401	Бичиг хэрэг	3,438,609.00	5,062,841.00
210402	Тээвэр, шатахуун	2,767,100.00	1,724,801.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,797,625.56	1,546,894.15
210404	Ном, хэвлэл	19,275,490.00	17,754,912.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,314,400.00	2,733,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,401,505.00	21,606,990.90
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,737,700.00	777,193.00
2105	Нормативт зардал	445,400.00	159,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	445,400.00	159,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,358,000.00	8,621,980.00

Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,092,000.00	
210604	Урсгал засвар	1,266,000.00	8,621,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,022,350.00	73,027,094.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,168,230.00	58,618,030.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	4,950,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	160,352.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	223,720.00	0.00
210807	Газрын төлбөр	5,050,400.00	7,111,230.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	180,000.00	687,482.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,416,027.16	153,464,037.34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,416,027.16	153,464,037.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,823,640.29	53,748,544.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	20,168,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,348,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	820,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,413,640.29	33,579,544.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,413,640.29	31,027,706.86
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг -нэмэлт санхүүжилт		2,551,838.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(78,589,128.24)	(80,690,768.57)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(78,589,128.24)	(80,690,768.57)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.19	(74,954,276.79)	18,091,847,536.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.19	(74,954,276.79)	18,091,847,536.00
2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.19	(74,954,276.79)	18,091,847,536.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.19	(74,954,276.79)	18,091,847,536.00
Тайлант үеийн үр дүн			(80,690,768.57)	(80,690,768.57)
2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.19	(155,645,045.36)	18,011,156,767.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	500,796,200.00	530,562,638.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,551,838.00
1200	Нийтлэг татварын бус орлого		2,551,838.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого		2,551,838.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,796,200.00	528,010,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	428,314,300.00	304,701,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	428,314,300.00	304,701,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,481,900.00	85,633,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	37,825,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,481,900.00	47,808,400.00
1330	Төсвийн захирагчдаас	-	137,676,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	137,676,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	500,371,200.00	504,545,638.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,371,200.00	504,545,638.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,844,739.71	421,570,744.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,903,411.81	225,377,843.37
210101	Үндсэн цалин	163,384,896.81	168,319,125.31
210102	Нэмэгдэл	54,014,515.00	36,085,545.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,504,000.00	16,540,175.66
210104	Урамшуулал	-	4,432,997.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,553,046.09	29,858,541.35
210201	Тэтгэврийн даатгал	21,889,474.01	21,022,467.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,493.01	2,303,178.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,574.42	1,785,422.76
210204	Ажилгүйдлийн даатгал	482,118.61	426,851.85
210205	Эрүүл мэндийн даатгал	4,823,386.04	4,320,621.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,393,029.25	27,805,704.51
210301	Гэрэл, цахилгаан	17,441,138.00	12,470,117.82
210302	Түлш, халаалт	14,145,833.77	13,259,377.69
210303	Цэвэр, бохир ус	1,806,057.48	2,076,209.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,662,925.56	11,721,544.15

**Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

210401	Бичиг хэрэг	2,098,000.00	1,797,280.00
210402	Тээвэр, шатахуун	2,558,100.00	1,641,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,097,625.56	1,546,894.15
210404	Ном, хэвлэл	825,000.00	481,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,314,400.00	2,733,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,769,800.00	3,521,220.00
2105	Нормативт зардал	4,251,000.00	1,432,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,251,000.00	1,432,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,691,980.00	904,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,338,000.00	-
210604	Урсгал засвар	7,353,980.00	904,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,389,347.00	124,469,911.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,602,347.00	104,818,329.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	160,352.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	336,600.00	324,000.00
210807	Газрын төлбөр	5,050,400.00	7,111,230.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	656,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,526,460.29	82,974,893.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	20,164,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,348,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	816,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,116,460.29	62,810,193.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,413,640.29	31,027,706.86
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг - нэмэлт санхүүжилт	702,820.00	31,782,486.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	425,000.00	26,017,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	425,000.00	26,017,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	425,000.00	26,017,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	425,000.00	26,017,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	425,000.00	26,017,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(425,000.00)	(26,017,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Данс ны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	442,377,400.00	411,349,693.14	(31,027,706.86)	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,377,400.00	411,349,693.14	(31,027,706.86)	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,700,700.00	391,684,993.14	(31,015,706.86)	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,509,100.00	220,944,845.97	(21,564,254.03)	91.1
210101	Үндсэн цалин	182,654,500.00	168,319,125.31	(14,335,374.69)	92.2
210102	Нэмэгдэл	43,978,600.00	36,085,545.00	(7,893,055.00)	82.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	16,540,175.66	664,175.66	104.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,738,800.00	29,309,626.93	(3,429,173.07)	89.5
210201	Тэтгэврийн даатгал	23,038,400.00	20,645,662.22	(2,392,737.78)	89.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,425,100.00	2,258,848.44	(166,251.560)	93.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,100.00	1,749,958.78	(190,141.22)	90.2
210204	Ажилгүйдлийн даатгал	485,000.00	423,196.11	(61,803.89)	87.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,850,200.00	4,231,961.38	(618,238.62)	87.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,740,200.00	27,805,704.51	(3,934,495.49)	87.6
210301	Гэрэл, цахилгаан	13,940,200.00	12,470,117.82	(1,470,082.18)	89.4
210302	Түлш, халаалт	15,352,900.00	13,259,377.69	(2,093,522.31)	86.4
210303	Цэвэр, бохир ус	2,447,100.00	2,076,209.00	(370,891.00)	84.8
2104	Хангамж, бараа материалын зардал	11,649,700.00	10,561,544.15	(1,088,155.85)	90.7
210401	Бичиг хэрэг	1,783,300.00	1,782,800.00	(500.00)	99.9
210402	Тээвэр, шатахуун	1,221,700.00	1,221,700.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,730,400.00	1,546,894.15	(183,505.85)	89.4
210404	Ном, хэвлэл	367,800.00	360,000.00	(7,800.00)	97.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,629,100.00	2,733,450.00	(895,650.00)	75.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,917,400.00	2,916,700.00	(700.00)	99.9
2105	Нормативт зардал	1,432,800.00	1,432,800.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,432,800.00	1,432,800.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,570,400.00	7,570,400.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,070,400.00	1,070,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,059,700.00	94,060,071.58	(999,628.42)	98.9

**Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,395,500.00	74,499,089.58	(896,410.42)	98.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	9,920,000.00	9,900,000.00	(20,000.00)	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	69,752.00	(15,248.00)	82.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	336,600.00	324,000.00	(12,600.00)	96.3
210807	Газрын төлбөр	7,166,600.00	7,111,230.00	(55,370.00)	99.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	656,000.00	656,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,676,700.00	19,664,700.00	(12,000.00)	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,676,700.00	19,664,700.00	(12,000.00)	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,348,700.00	19,348,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	316,000.00	(12,000.00)	96.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	442,377,400.00	411,349,693.14	31,027,706.86	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,377,400.00	411,349,693.14	31,027,706.86	
131001	Улсын төсвөөс санхүүжих	442,377,400.00	411,349,693.14	31,027,706.86	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
610001	Төсвийн байгууллага	1	1.	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	
620003	Үйлчлэх ажилтан	7	7	-	
620004	Гэрээт ажилтан			-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		88,185,238.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		88,185,238.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		55,902,751.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,432,997.40
210104	Урамшуулал		4,432,997.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		548,914.42
210201	Тэтгэврийн даатгал		376,804.78
210202	Тэтгэмжийн даатгал		44,329.97
210203	ҮОМШӨ-ний даатгал		35,463.98
210204	Ажилгүйдлийн даатгал		3,655.74
210205	Эрүүл мэндийн даатгал		88,659.95
2104	Хангамж, бараа материалын зардал		1,640,000.00
210401	Бичиг хэрэг		14,480.00
210402	Тээвэр, шатахуун		600,000.00
210404	Ном, хэвлэл		421,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		604,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,037,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		10,037,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,243,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		39,152,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		90,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,282,486.18
2132	Бусад урсгал шилжүүлэг		500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		31,782,486.18
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		31,782,486.18
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		88,185,238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		88,185,238.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		37,825,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,360,238.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Богд хааны ордон музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Богд хааны ордон музей нь үзмэрийн үйл ажиллагаа явуулдаг, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм

Богд хааны ордон музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Үзүүлэлийн шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны зохистой шийдэлтэй, шинэ мэдээлэл багтаан, тогтмол баяжуулан шинэчлэн дэглэнэ.
- Сан хөмрөгөө төлөвлөгөөтэй байнга баяжуулж, иж бүрдүүлэх, эрэн сурвалжлах, хайгуул цуглуулгын ажлыг зохион байгуулна;
- Сан хөмрөгийн тохирсон нөхцөлийг бүрдүүлж хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ;
- Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ;
- Музейн үзмэрт түшиглэн судалгаа шинжилгээний ажлыг дангаар болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран явуулж, үр дүнг нийтийн хүртээл болгоно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” батлагдсан байна.
- Музейн тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;
- Соёлын тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нь

дотоод хяналтын ажилтан байхгүй, тухайн оны дотоод аудитын төлөвлөгөө байхгүй зэргээс үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллага нь дотоод аудитын орон тооны тусдаа ажилтан байхгүй бөгөөд хяналт шалгалтыг зохион байгуулахдаа нийтлэг журмын дагуу нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгон ажилладаг

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын 580,451.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,804.5 мянган төгрөгөөр, тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Богд хааны ордон музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 77,305.3 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгийн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	66,986.4	71,626.4	4,640.0
Урьдчилгаа	83,430.0	69,180.0	(14,250.0)
Бараа материал	234,723.1	236,260.9	1,537.8
Үндсэн хөрөнгө	17,708,283.7	17,639,050.6	(69,233.1)
Нийт хөрөнгө	18,093,423.1	18,016,117.8	(77,305.3)
Өр төлбөр	1,575.6	4,961.1	3,385.5
Засгийн газрын оролцоо	18,091,847.5	18,011,156.8	(80,690.7)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,093,423.1	18,016,117.9	(77,305.2)

Авлага дансны үлдэгдэл 71,626.4 мянган төгрөг болж 4,640.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдаас авах авлага 154.4 мянга, байгууллагаас авах авлага 24,478.2 мянган төгрөгийн авлагуудыг барагдуулж татаас санхүүжилтийн авлага 29,230.6 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна. Авлагын дансны үлдэгдэлд удаан жилийн насжилттай авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 236,260.9 мянган төгрөг болж, 1,537.8 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн 124.3 мянга, аж ахуйн материал 5,993.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, эм боох материал 64.6 мянга, бичиг хэргийн материал 3,034.2 мянга, түлш шатах тослох материал 83.1 мянга, бусад хангамжийн материал 1,397.6 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,639,050.6 мянган төгрөг болж 69,233.1 мянган төгрөгөөр буурсан нь 84,230.9 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, 153,464.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 4,961.0 мянган төгрөг болж 3,385.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад байгууллагад өгөх өглөг 3,293.0 мянган төгрөгөөр өсөж голлох нөлөө үзүүлжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 18,011,156.7 мянган төгрөг болсон нь тайлант онд 80,690.7 мянган төгрөгөөр алдагдалтай ажилласантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Богд хааны ордон музейн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 442,377.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 442,377.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 442,377.4 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 442,377.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 442,377.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 442,377.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 411,349.7 мянган төгрөг зарцуулж, 31,027.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 411,349.7 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь цалин хөлс ба нэмэгдэл урамшуулалд 220,944.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 29,309.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 27,805.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 10,561.5 мянган төгрөг, норматив зардалд 1,432.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 7,570.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 94,060.1 мянган төгрөг тэтгэвэр тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж шагналд 19,664.7 мянган төгрөгийг батлагдсан төсвийн дагуу бүрэн зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 арга хэмжээнд 31,027.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	348,630.60	317,602.9	31,027.7	91.0
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,496.00	10,496.00	0	100.0
3	80219	Харуул хамгаалалтын зардал	35,820.00	35,820.00	0	100.0
4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	19,600.00	19,600.00	0	100.0
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	19,676.70	19,676.70	0	100.0
6	81908	Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	8,154.1	8,154.1	0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 37,825.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 50,360.2 мянга, нийт 88,185.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 4,981.9 мянга, хангамж бараа, материалын зардалд 1,640.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 10,037.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 39,243.2 мянга, бусад урсгал шилжүүлэгт 500.0 мянга, нийт 88,185.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 31,782.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээнд зориулан нийт 442,377.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 411,349.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 92.9 хувь байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тус байгууллага нь 2021 онд “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой байгууллага орчмын бүс, үзмэрийн байр, өрөө тасалгаанд цэвэрлэгээ, ариутгал хийж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 169 мэдээллийг бүрэн байршуулж, 4 мэдээллийг (Нэмэлт үйл ажиллагааны орлого, үндсэн үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зам талбай тохижуулах гэсэн 617,000.0 мянган төгрөгийн арга хэмжээ) хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.1, 1.4 дэх заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд “Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах” гэсэн заалтыг хэрэгжүүлж 8,723.0 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

2. Тайлангийн жилд тус байгууллагын сантехникч нь өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд түүний орон тоон дээр ажилтан шинээр авч ажиллуулж нийт 4,698.9 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,960.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар жуулчдын компанид өгсөн үзвэр үйлчилгээний ваучертай холбоотой тооцооны авлагыг үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 54,140.7 мянган төгрөгийн төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 49,441.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,698.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 4,698.9 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5,804.5 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Харилцагч байгууллагууд руу гаргасан 35,176.9 мянган төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн.
2. Цалингаас суутгасан 3,844.9 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн.
3. Хөрөнгийн даатгалд төлсөн 7,920.0 мянган төгрөгийн төлбөрийг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн.
4. Цалингийн урьдчилгаа 2,500.0 мянган төгрөгийг авлага дансанд бүртгэлгүй орхигдуулсан.

4.2 Албан шаардлага

Тайлангийн жилд тус байгууллагын сантехникч нь өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд түүний орон тоон дээр ажилтан шинээр авч ажиллуулж нийт 4,698.9 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2 "шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Харилцагч байгууллагууд руу гаргасан 35,176.9 мянган төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн	Тооцооны дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	35,176.9	1	35,176.9						
2	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Цалингаас суутгасан 3,844.9 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн	Тооцооны дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	3,844.9	1	3,844.9						
3	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Хөрөнгийн даатгалд төлсөн 7,920.0 мянган төгрөгийн төлбөрийг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн	Хөрөнгийн ангиллыг зөв хөтлөх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	7,920.0	1	7,920.0						
4	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Цалингийн урьдчилгаа 2,500.0 мянган төгрөгийг авлага дансанд бүртгэлгүй орхигдуулсан	Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан тул зөвлөмж хүргүүлэх	1	2,500.0	1	2,500.0						
5	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Өндөр насны тэтгэвэрт гарсан орон тоон дээр ажилтан шинээр авч ажиллуулсан	ЗГ-ын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах	1	4,698.9					1	4,698.9		
	ДҮН				5	54,140.7	4	49,441.8			1	4,698.9		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Богд хааны ордон музей	АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 170 мэдээлэл оруулахаас 4 мэдээлэл хугацаа хоцроосон мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх	1						1			
	ДҮН				1						1			
НИЙТ ДҮН					6	54,140.7	4	49,441.8			1	4,698.9		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 266 /АД/50458
АХГ-2022/196/НА-СТА-ТУС

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 173 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.2.4 "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Богд хааны ордон музейн захирал Ц.Эрдэнэбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Л.АМАРЗАЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 265/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/196/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлангийн жилд тус байгууллагын сантехникч нь өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд түүний орон тоон дээр ажилтан шинээр авч ажиллуулж нийт 4,698,855.40 төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Энэ нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэг "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангаж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богд хааны ордон музейн захирал Ц.Эрдэнэбаатар, нягтлан бодогч Г.Пүрэвсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Л.АМАРЗАЯА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-230.Docx

0010800746

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]